

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Мягмар гараг
Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-25

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./ 4-25

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
10 дугаар сарын 22-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 31 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Н.Номтойбаяр;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Бямбацогт, Т.Доржханд, Ц.Сандаг-Очир,
Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болох “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэхийг хойшлуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Солонгоо, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батхуяг, Монгол

Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн хэлтсийн мэргэжилтэн С.Гэлэгжунай, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, мэргэжилтэн П.Энхманлай, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүү, төсвийн судалгааны газрын ахлах шинжээч З.Анар, Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, С.Зулпхар, Г.Уянгахишиг, Э.Болормаа, О.Алтангэрэл, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Солонгоо, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батхуяг, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл нар үг хэлэв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 17.3.5.1-д тусгагдсан “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын

төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох” гэсэн хөтөлбөрийн нэрийг “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 10
Бүгд: 15
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 22 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
09 цаг 31 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны
эрхэм гишүүдийн амрыг эрье.

Байнгын хорооны хуралдаанд
ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя.
Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн
байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн
ирсэн байна. Сархадын Зулхар гишүүн
ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж
гишүүн ирсэн байна. Одонгийн Цогтгэрэл
гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ
Жудгийн Баярмаа гишүүн ирсэн,
Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн,
Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн,
Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн,
Батын Батбаатар гишүүн ирсэн,
Энхбатын Болормаа гишүүн,
Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн,
Гончигдоржийн Уянгахишиг гишүүн нар
ирсэн.

Ирц бүрдсэн тул хуралдааныг
эхлүүлж байна. Байнгын хорооны
гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ирц
56 хувьтай, Байнгын хорооны 2024 оны
10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан
нээснийг мэдэгдье. Хэлэлцэх асуудлыг
танилцуулъя.

1.Монгол Улсын 2025 оны төсвийн
тухай, Үндэсний баялгийн сангийн 2025
оны төсвийн тухай, Нийгмийн
даатгалын сангийн 2025 оны төсвийн
тухай, Эрүүл мэндийн даатгалын
сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн
төсөл Засгийн газрын 2024 оны 8 дугаар
сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр
дахь хэлэлцүүлэг санал, дүгнэлтээ

Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн
болно гэж, хүргүүлнэ.

2.Байнгын хорооны тогтоол
“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй
байдлын дэд хорооны даргыг сонгох”
гэсэн ийм 2 асуудал байна.

Байнгын хорооны хэлэлцэх
асуудалтай холбоотойгоор саналтай
гишүүд байна уу?

Алга байна.

Хоёрдугаар асуудал дээр Байнгын
хорооны тогтоолын төсөл гэж байгаа.
Энэ дээр бүлгээс шийдвэр гараагүй тул
энэ хоёрдугаар асуудлыг хойшлуулъя
гэсэн саналтай байж байгаа. Санал
хураана.

Горимын саналаар санал хураая.
Хоёрдугаар асуудлыг Байнгын хорооны
тогтоолын төслийг хойшлуулъя гэсэн
биш ээ, Халдашгүй байдлын дэд хороо
хойшлуулъя гэснээр санал хураалт
явуулъя санал хураалт. Минийх орчихсон
байна шүү.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Багахан улс төржинө шүү. Ингээд
хэлэлцэх асуудалдаа оръё доо.

**Монгол Улсын 2025 оны төсвийн
тухай, Үндэсний баялгийн сангийн 2025
оны төсвийн тухай, Нийгмийн
даатгалын сангийн 2025 оны төсвийн
тухай, Эрүүл мэндийн даатгалын
сангийн 2025 оны төсвийн тухай
хуулийн төслийн хоёр дахь
хэлэлцүүлгийг эхлүүлъя.**

Ажлын хэсгийг танилцуулъя.
Монгол Улсын 2025 оны төсвийн тухай
хуулийнхнаас эхэлье. Б.Баасандорж
Улсын Их Хурлын Ерөнхий нарийн
бичгийн дарга, Б.Энх-Амгалан
Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд
дарга, Л.Цэдэвсүрэн Төрийн албаны
зөвлөлийн дарга, Р.Эрдэнэбүрэн Монгол
Улсын сайд, 20 минутын хот Үндэсний

хорооны дарга, Д.Баянбилиг Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, Б.Солонгоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Л.Лхагвасүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний газрын хэлтсийн дарга, Ж.Оюунгэрэл Сонгуулийн ерөнхий хорооны ерөнхий нягтлан бодогч, Б.Эрдэнэбат Үндсэн хуулийн цэцийн ахлах нягтлан бодогч, Б.Мөнх-Оргил Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга, З.Лхагвадорж Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга, Б.Жавзан Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга, Б.Батхуяг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Б.Ганбаатар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын референт, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Үндэсний аудитын газраас оролцох бүрэлдэхүүн Д.Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Ц.Наранчимэг Санхүү-Нийцлийн Аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Л.Мөнхцацрал Санхүү-Нийцлийн Аудитын газрын аудитын менежер, Ю.Энхтуяа Гүйцэтгэл-Нийцлийн Аудитын газрын аудитор менежер, Ц.Батсүх Санхүү-Нийцлийн аудитын ахлах аудитор, Ш.Наран Санхүү-Нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ж.Мөнхбилиг Санхүү-Нийцлийн Аудитын газрын аудитор, Ж.Мөнхбилиг Санхүү-Нийцлийн Аудитын газрын аудитор, Г.Оюунтөгөлдөр Санхүү-Нийцлийн Аудитын газрын аудитор, Сангийн яамнаас оролцох бүрэлдэхүүн Б.Жавхлан Сангийн сайд, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн

дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн газрын дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Н.Наранцэцэг Сангийн яамны Төсвийн зарлагын ахлах шинжээч, Ж.Төгөлдөр Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Э.Цолмон Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, С.Гэлэгжунай Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн, П.Энхманлай Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Б.Анар Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн, Р.Хангал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, С.Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Сугармаа Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга, Т.Сумъяа Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Т.Анхбаяр Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Б.Энхжин Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Ч.Мөнхшүүр Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, З.Анар Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын ахлах шинжээч, Т.Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн

хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Б.Энхжин Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Монгол Улсын яам тэр чигээрээ л ирчихсэн л болж таарч байна даа энэ ч одоо.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг нээе. 5 дугаар микрофон.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Ирэх 2025 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас төсвийн бодлогыг бүтцийн хөгжилд зайлшгүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс ялгаатай онцлог болж байна.

Шинэ 30 жилийн хөгжлийн суурийг тавих томоохон төслүүдийг эхлүүлэх, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн 2025 оны төсөвт нийгмийн бодлогын чиглэлээр тусгасан онцлог арга хэмжээг дурдвал,

1.Төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлнэ. Монгол Улсын Засгийн газраас нийт

төрийн албан хаагчдын цалинг 2023 оны 7 дугаар сарын 1-нээс дунджаар 40 хувиар, 2024 оны 4 дүгээр сарын 1-нээс төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар тус тус нэмсэн.

Мөн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн төрийн захиргаа, төрийн үйлчилгээ болон улс төрийн албан тушаалын албан хаагч сум, тосгонд ажиллаж байгаа бол 40 хувиар, аймгийн төв болон Нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа бол 20 хувиар үндсэн цалингаас тус тус тооцож 24 оны 4 дүгээр сарын 1-нээс олгож байна.

Ирэх 2025 онд 226 мянган төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлэхээр тооцлоо. Монгол Улсын Засгийн газрын 2024 он, 24-28 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт төвийн бүсийг эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүсээр тодорхойлж энэ хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, судалгаа, хөгжлийн төв байгуулж, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг үе шаттайгаар нүүлгэх зорилт тусгагдсан.

Энэ дагуу хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагуудын хамт орон нутаг руу 2025 онд нүүлгэх ажлалыг зохион байгуулна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн бодлого хэрэгжсэнээр төсвийн нийт орлогын хэмжээ 36.8 их наяд, төсвийн нийт зардал 35.8 их наяд, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1.9 их наяд төгрөгийн ашигтай байхаар тусгалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 25 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 25 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 25 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл хийсэн Аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

Загджав даргын, аудиторын микрофоныг нээе, 4.

Д.Загджав: Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж үнэлэхэд чиглэсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны

хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг ишийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шат болон Нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 864.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.6 хувь, нийт зарлага 35 их наяд 795.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909.5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 980 аравны, 930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт төсвийн 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ. Үүнд,

Үндсэн хуулийн цэцийн дарга 6.1 тэрбум, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга 39.8 тэрбум төгрөг, Улсын Их Хурлын дарга 191 тэрбум төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайд 438.5 тэрбум, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга 361.3 тэрбум, Сонгуулийн ерөнхий хорооны дарга 18.6 тэрбум, Төрийн албаны зөвлөлийн дарга 21.9 тэрбум, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга 33.1 тэрбум, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга 24.1 тэрбум, Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны төсвийн төслийг 2024 оны тодотгосон төсөлтэй харьцуулахад Монгол Улсын Ерөнхий сайдын багцын Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төсөвт төвлөрүүлэх орлогыг 0.4 тэрбум төгрөгөөр, харьяа төсөл байгууллагын өөрийн орлогыг 0.34 тэрбум төгрөгөөр, Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын харьяа төсөвт байгууллагын

өөрийн орлогыг 0.1 тэрбум төгрөгөөр, Төрийн албаны зөвлөлийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 0.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 122.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд,

Үндсэн хуулийн цэцийн даргын урсгал зардлын төсвийг 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 6.1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 0.8 хувь, 8, 0.8 тэрбум, эд хогшилын урсгал засварын зардал 0.2 тэрбум, бусдаар үйлчлүүлэх ажил үйлчилгээний хураамж 1 аравны, 0.1 тэрбум төгрөгийн зардалтай холбоотой байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын урсгал зардлын төсвийг 8.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 38.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 2.3 тэрбум, томилолт, зочны зардал 3.2 тэрбум, бараа, үйлчилгээний бусад зардал 2.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтын төсвийг 2 төсөл, арга хэмжээнд нийт 1 тэрбум төгрөгийг улсын төсөвт санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын урсгал зардлын төсвийг 55.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 170, 75.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 23.6 тэрбум, бусдаар гүйцэтгээлэх ажил үйлчилгээний хураамж 8, 4.8 тэрбум, бараа үйлчилгээний бусад зардал 14.9 тэрбум, бусад урсгал шилжүүлэх 1.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 2 төсөл, арга хэмжээнд нийт 15.6 тэрбум төгрөгийн улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын урсгал зардлын төсвийг 53.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 370.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэлт урамшуулал 22.4 тэрбум, бусдаар үйлчлүүлэх ажил үйлчилгээний хураамж 8.6 тэрбум, бараа, үйлчилгээний бусад зардал 27.3 тэрбум төгрөгийн зардал тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг нийт төсөл, арга хэмжээнд нийт 1.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын урсгал зардлын төсвийг 43.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 126.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэлт урамшуулал 9.9 тэрбум, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2.3 тэрбум, эд хогшил, урсгал засварын зардал 1.1 тэрбум, томилолт, зочны зардал 2.7 тэрбум, бусдаар үйлчлүүлэх ажил, үйлчилгээний хураамж 18.3 тэрбум, бараа, үйлчилгээний бусад зардал 5.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 18 төсөл, арга хэмжээ, нийт 234.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын урсгал зардлыг 54.6 тэрбум төгрөгөөр бууруулж, 18.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөнд бараа, үйлчилгээний бусад хуваарилалттай холбоотой байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлын төсвийг 14.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 21.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэлт урамшуулал 2.5 тэрбум, эд хогшил, урсгал засварын зардал 1.1 тэрбум, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хураамж 6.8 тэрбум

төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын төсөвт хөрөнгө оруулалтын зардлын төсөвт хөрөнгө оруулалтын төсвийг 4 төсөл, арга хэмжээнд нийт 33.1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын урсгал төсвийг 4.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 19.3 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 4 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж 1 тэрбум төгрөгөөр тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 1 төсөл, арга хэмжээ нь нийт 4 аравны, 8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан гэж дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газраас Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхний гар дээр тараасан байгаа.

Ингээд хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх

асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулт байвал гишүүд саналаа өгнө үү. Асуулт асуух гишүүд саналаа өгье.

Цогтгэрэл өгнө гэсэн тээ? Зулхар гишүүнээр тасаллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.3-д Байнгын болон дэд хорооны хуралдаанд гишүүд Байнгын, дэд хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж, үг хэлж болно гэж заасан байгаа.

Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Баярлалаа. Бүгдээрэнд нь энэ өглөөний мэндийг хүргэе. 3 асуулт байна. Тамгын газраас хийсэн төсвийн төслийн талаарх мэдээлэлтэй холбоотойгоор нэгдүгээрт уг нь 20 минутын хот Үндэсний хорооны дарга, сайдаас асуумаар байгаа юм. Эсвэл ажлын албанаас нь байгаа болов уу ариулах хүн? Асуултаа асуучихъя. Ажлын албанаас нь байгаа бол яачих. Сайд нар бас уг нь байгаад өөрсдөө харуулбал уг нь их сайн байгаа юм.

20 минутын хот Үндэсний хорооны даргын 25 оны төсвийн төсөл дээр автомашингүй гудамж, авто зогсоолын ТЭЗҮ, явган хүн, энгийн болон цахилгаан хөдөлгүүрт дугуйн зам байгууламжийн ТЭЗҮ зураг, төсөв гэсэн асуудлууд бол 3 ТЭЗҮ-ийн 2 нь бол ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энэ яг хаана хаана хийгдэх анхан шатны судалгаанд гарсан асуудал юм уу? Нийслэл хотын хийгдэж байгаа асуудалтай хэр уялдаж байгаа юм бол? Энэний талаар дэлгэрэнгүй мэдээллийг нь авах гэсэн юм. Автомашингүй гудамжийг хаагуур хийх гэж байгаа, тэгээд явган хүн, энгийн болон цахилгаан хөдөлгүүрт дугуйны зам

байгууламжийн замыг хаагуур татаж байгаа талаар мэдээллийг нь өгөөч гэдэг.

Хоёрдугаарт, Төрийн албаны зөвлөлөөс асуумаар байна. Энэ бид нарын одоо батлах гэж байгаа төсөв ер нь жилийн дотор 25 онд хэрэгжүүлээд ямар үр дүнд гарах юм гэдэг энэ үзүүлэлтүүдийг бид нар бас хардаг. Ер нь хэр үр дүнтэй юу руу чиглэсэн төсөв байна вэ гэдгийг тээ. Тэгэхээр Төрийн албаны зөвлөлийн дарга дээр тавигдаж байгаа төсвөөс харахаар зорилтот юмнуудаа харахаар төрд учруулсан хохирлыг нөхөн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ гээд зорилт нь бол 100 мянга, 100 сая төгрөгөөс 250 сая төгрөг болтол ихэснэ гэдэг ийм зорилт тавьчихсан байгаа юм. Тэгэхээр энэ яг Төрийн албаны зөвлөлийн хувьд нөгөө төрийн албан хаагч маань төрд учруулсан хохирол байх юм бол өөрөө нөхөн төлнө гэж байгаа. Энэ ер нь явц, энэ төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлууд ер нь хэр явж байгаа юм бэ?

Дээр нь энд зөвхөн төрд төвлөрүүлэхээс гадна иргэд, аж ахуйн нэгжүүдэд хохирол учруулдаг энэ шийдвэрээс болоод. Энэ асуудал нь Төрийн албаны зөвлөлийн энэ Кэй Пи Ай буюу энэ төсвийн зарцуулалт, энэ зорьж байгаа зорилт дээр хэр уялдаж явдаг юм? Энэний талаар мэдээлэл өгөөч.

Гуравдугаарт, Хяналтын Үндэсний хороо билүү тээ? Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга сайд өөрөө байж байгаа учраас асуулт асууя. Таны яг сайдын эрхэлсэн хүрээний асуудлыг иргэд тэр болгон мэддэггүй, яг юу хийдэг юм бэ гэдгийг их цөөхөн ийм чиг үүрэг юун дээр байх шиг байна хууль дээр. Таны Кэй Пи Ай буюу яг гүйцэтгэх засаглалын удирдлагын хувьд юу хийх юм бэ гэдэг энэ дүнгүүд ирсэн байгаа. Холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг сайжруулсан байна. 2 ширхгийг хийнэ гэж байна. Энэ 2 хууль тогтоомж чинь ямар хууль тогтоомж байгаад та энийг сайжруулснаар ямар үр дүнд гарна гэж үзэж байгаа юм?

Дээр нь иргэн хуулийн этгээд болон төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлсэн байна 100 хувь гээд. Таны яах вэ сай яам биш ээ, Үндэсний хороо бол анх удаа үйл ажиллагаа явж байгаа.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дахиад 1 минут Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Суурь үзүүлэлт гэдэг юм байхгүй. Тэгэхээр та бол их өндөр амбицтай буюу төрийн үйлчилгээ, гүйцэтгэх засаглалын удирдлага болон иргэн, хуулийн этгээд болон төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг 100 хувь дээшлүүлнэ, 100 хувь ханамжтай байна гэсэн ийм зорилт тавьж байх шиг байна. Энэ хүрээндээ яг та ямар чиг үүрэг, ямар үйл ажиллагаа хийж байгаа юм гэдгийг яг иргэд олон нийтэд маш ойлгомжтойгоор хэлж өгвөл бас хэн хэндээ ойлгомжтой байна. Тэгэхгүй бол сошиалаар янз бүрийн юм явдаг. Яг юу судлах гээд хаашаа явдаг юм, иргэд яг энэ Үндэсний хороо яг юу хийдэг юм гэдэг дээр ойлголт муутай байгаа учраас үүнийгээ бас нэг сайхан тайлбарлаад өгөөч гэж хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбүрэн сайд байна уу? Энэ 20 минутын хот Үндэсний хорооноос өөр хүн байна уу?

Алга байна уу? Дуудуулчихсан байна. Тэгвэл 2 дахь асуулт Төрийн албаны зөвлөл 7 номерын микрофон, Цэдэвсүрэн дарга.

Л.Цэдэвсүрэн: Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны тухай хуульд Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлэх чиг үүргийн чухал нэг статус нь таны саяын асуусан иргэнийг эсвэл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчдыг төрийн албанаас хууль бусаар халах, чөлөөлөх, сахилгын арга хэмжээ

авах тохиолдолд энийг нь шүүх буруутай гээд тогтоочихсон тохиолдолд энийх нь, хоёр дахь нь төрийн албаны төв байгууллага буюу зөвлөл тогтоосон тохиолдолд тэр буруутай шийдвэр гаргасан этгээдээс нөхөн төлбөрийг төрд буцааж төлүүлэх ийм үүргийг хэрэгжүүлж байгаа.

2019 оноос эхлээд энэ ажлыг нэлээн идэвхтэй хэрэгжүүлээд явж байна. Өнөөдрийн байдлаар яг одоо бид нар бас энэ асуудлаар Төрийн албаны зөвлөл дээр холбогдох хууль, хяналтын байгууллагуудтайгаа хамтраад уулзалт, хэлэлцүүлэг хийгээд явж байна. Ер нь энэ бол бүртгэлийг эхлээд хөтлөх ёстой юм байгаа юм. Бүртгэлийг хөтлөөд 3.7 тэрбумын яг ийм нэхэмжлэхийг бид нар шүүхэд гаргаад явж байгаа.

Яагаад Төрийн албаны шүүхэд нэхэмжлэл гаргаад байгаа юм гэхээр хуулиараа төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг нь Төрийн албаны зөвлөлд Төрийн албаны хуулиар нь олгочихсон байгаа юм. Өнөөдрийн байдлаар шүүхээс 981.7 сая төгрөгийг буруутай этгээдээр нь төлүүлэх шийдвэрийг гаргуулаад, Төрийн сангийн, Сангийн яамны дансанд 840 гаруй сая төгрөгийг буцаан төлүүлээд явж байна. Энэ бол зөвхөн томилох эрх бүхий этгээдийн буруутай шийдвэрийн нөхөн төлөлт, бусад нөгөө хувийн аж ахуйн нэгж, иргэн байгууллагын төрд учруулсан хохиролтой холбоотой нөхөн төлөлтийн асуудал манайд хамаарахгүй.

2025 оны төсвийн төсөл дээр бид нар Сангийн яамтайгаа ярьж байгаад энэ буцаан төлөлт дээр 200 саяын орлогыг оруулъя, өмнө нь тийм тохиолдол байгаагүй юм байна лээ. Тэгээд энийгээ оруулъя гэж байгаа. Гэхдээ бид нар хэдийгээр энэ дээр акцент өгөөд ажиллаад байх нь бас нэг талдаа буруу. Хэзээ төрийн албан хаагч буруу шийдвэр гаргах юм бол гэж ачаа байхаасаа илүүтэй аль болохоор тэр төрийн албан хаагчдыг эрсдэлээс сэргийлж, буруу шийдвэр гаргуулахгүйн

төлөө Төрийн албаны зөвлөл 2025 оноос эхлээд нэлээн ажиллаж гэсэн ийм бодлого зорилттой байгаа.

Үр дүнгийн хувьд бид нар энэ тоог багасгана, багасгана. Тэгэхгүй бол буруутай албан тушаалтны маань тоо ихсээд, төрийн албан хаагчид хохирох эрсдэлүүд илүү их нэмэгдэх юм. Хэрвээ тоо ихсэх юм бол. Тэгээд аль болохоор шийдвэрүүдийг зөв гаргахын төлөө Төрийн албаны зөвлөлөөс өнөөдөр хуртэл яам, агентлагуудаар хяналт, шалгалт хийгээд явж байна. Алдаа засах боломжийг энэ томилох эрх бүхий этгээд нарт бас олгож байгаа. Юу юугүй шүүхэд өгөхөөсөө илүүтэй та алдаагаа зас, буцаагаад энэ хохирлын асуудлыг шийд, тэрний дараа бүр болохгүй бол шүүхийн журмаар энэ асуудлыг шийднэ гэдэг зарчмаар явж байгаа учраас 25 онд бол энэ дээр нэлээн үр дүн гарна гэж төлөвлөж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: 20 минут Үндэсний хорооны дарга Эрдэнэбүрэн сайд орж ирсэн байна. Хэддүгээр микрофон дээр байна? Аан за Эрдэнэбүрэн сайдын, Эрдэнэбүрэн гишүүний. Аан за.

Р.Эрдэнэбүрэн: Байна уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ автомашингүй гудамж зогсоолын ТЭЗҮ, техник, эдийн засаг, зураг, төсөв Улаанбаатарт гээд мөнгө тавиулж явсан. Ер нь яах вэ Улаанбаатар хотын хот төлөвлөлтийнхөнтэй бас ярьж байгаа. Энэ А бүс дээрээ аль болохоор хэд хэдэн газар автомашингүй гудамж би бий болгоё. Тэгэхгүй бол явах газаргүй дандаа, нэг бол машины зогсоол болчихсон байдаг.

Тийм учраас одоо ялангуяа энэ машины зогсоол болгоод байгаа энэ талбайнуудыг давхар зогсоолуудтай болгож өгье. Тэгээд машинуудыг нь тийшээ оруулъя. Аль болох, тийм, тэгж тийм байдлаар шийдье ээ гээд 5, 6-н

газар төлөвлөчихсөн байгаа. Энэ төлөвлөсөн хэсгүүдийг бол дахиад ярилцаад ингээд явж болох байх гэж ингээж бодож байгаа. Хотоос бас санал аваад явж байгаа тийм л юм байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хаагуур хаагуур? Одоо хэлэх бололцоо байна уу? Хаана хаана төлөвлөж байгаа юм?

Р.Эрдэнэбүрэн: Дугуйн зам, скүүтэр гээд бүүр Москва хорооллоос наашаа хотын төвөөр хөндлөн нэг зам яасан. Бүүр энэ 14 онд гаргачихсан байсан юм байна лээ. Тухайн үед Гудамж төслийнхөн гэж ажиллаж байх үедээ гаргачихсан байсан тийм трасс байдаг. Тэгээд энэ трасс харьцангуй чөлөөлөөд, дахиад янзлаад явахад болохоор юм байна гээд энэ хотын удирдлага ч гэсэн бас энийг их, энэ саналыг их дэмжиж байгаа. Тэгээд энэ трассаа чөлөөлөлт багатай юм байна энийгээ үргэлжлүүлээд явъя гэж ингэж үзэж байгаа. Тэгээд энэ юуг нь тодорхой юуг бол үзүүлэх юутай оруулж ирээд танилцуулъя. Хаана хаана төлөвлөж байгааг.

Ж.Бат-Эрдэнэ: Цаашидаа болохгүй бол энэ ажлын албаныхангаа дагуулж ирж байгаарай. Өөрсдөө хариулж чадахгүй бол тийм.

Дараа нь Одбаяр сайд.

Э.Одбаяр: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар 2022 оны 11 сарын 1-ний өдөр батлагдсан Засгийн газар дахь хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэхээр шинэ тутам байгуулагдсан байгууллага байгаа. Тэгээд кабинетын зүгээс төрийн албаны уламжлалт шинэтгэл, бодлогын үргэлжлэлийг хангах зорилгоор Ди Эм Эй буюу Дизайн Мониторинг Эволюшин гээд олон улсын энэ хяналт, үнэлгээний цогц системийг Монголд нэвтрүүлэхээр Азийн бүтээмжийн холбоотой хамтарч

ажиллаж байгаа. Тэгээд тэр чиглэлийн нэмэлт мэдээллийг миний араас Засгийн газрын Хэрэгжүүлэх газрын дарга өгөх байх.

Ер нь бол яах вэ гэхээр олон нийтэд энэ салбар, энэ чиг үүргийн талаар ойлголт, мэдээлэл дутуу байх нь бас аргагүй байх. Одоо үйл ажиллагаа явуулаад нэг жил хагас бил үү хугацаа болж байгаа. Ерөнхийдөө энэ гүйцэтгэх ажиллагаа явуулах чиг үүрэгтэй 3 байгууллагаас бусад Засгийн газраас томилогддог төрийн албан хаагчид болоод төрийн өмчит аж ахуйн нэгж, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны санхүүгээс бусад бүх төрийн чиг үүрэг дээр хяналт шалгалт хийх шаардлагатай тохиолдолд Ерөнхий сайдын зүгээс чиглэл өгсөн тохиолдолд төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ийм байгууллага байгаад байгаа юм.

Үндсэндээ засгийн бодлого, төлөвлөлт, хяналт гэдэг хоёр зүйлээ, өмнө нь хамт байсан зүйлээ хоёр тусад нь салгаад эхлээд явж байгаа ажил гэж ойлгож болно. Тэгээд Батхуяг дарга нэмэлт тайлбар өгөх нь бас зөв байх.

Ж.Бат-Эрдэнэ: Хэнээр хариулуулъя гэнэ ээ нэмэлт? Цаашаагаа очоод суу даа. 2 номер дээр очоод суучих. Одбаяр даргатай ямар үйл ажиллагааны ямар уялдаатай байгаа билээ тэрийгээ хэлээрэй. Танаар хариулуулах гээд байна шүү дээ. 2 номерын микрофон.

Б.Батхуяг: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийг гүйцэтгэгч Батхуяг байна.

Саяын асуусан асуултад манай байгууллагын дурдагдсан асуудал байгаа. 1996 оноос Засгийн газар өөрөө энэ дотоод хяналттай болсон. Үүнээс авхуулаад өнөөдөр 2023 оны 1 сарын 1-

нээр тусдаа Засгийн газрын байгууллага болж гарсан, мөн хууль нь батлагдсан. Өнөөдөр ингээд сайдын түвшинд төлөвшөөд явж байгаа ийм алба байгаа.

Миний хариулах гишүүний гол асуулт бол 2024-28 оны Засгийн газрын үйл ажиллагаанд орсон манай байгууллагын нэлээн томоохон зорилтуудыг бид нар тусгаж өгсөн байгаа. Нэлээн амбицтай бас зорилтууд оруулж өгсөн. Үүнтэй уялдаад Ерөнхий сайдын 100 хоногийн ажлын төлөвлөгөөнд манай сайдын эрхлэх хүрээний 3 асуудал орсон байгаа. Үүний нэг бол 96 оноос хянаснаар өнөөдрийг хүртэл хянасан Засгийн газрын хяналтын хяналт, үнэлгээний тогтолцоог солих том ажлуудын нэг бол төлөвлөгдөж орсон. Цаг хугацааны хувьд нэлээн давчуу учраас бид.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 2 номерын микрофоныг дахиад 1 минутаар сунгая. Өнгөрсөн 1 жил гарангын хугацааны түүхтэй байгууллага хэдий ч энэ 100 хоногийн ажлын төлөвлөгөөг бид нар маш хурдтай хийхийн тулд бас маш олон ажлууд төлөвлөлөө. Өнөөдрийн хэмжээнд Засгийн газрын захиргааны байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг сахиулах, хууль ёсны болгох, хууль тогтоомжийг биелүүлэх гээд маш олон өндөр, үзүүлэлттэй байгууллага байгаа учраас бид нар өнөөдөр хамгийн гол солих энэ төрийн албан хаагчдын нийтлэг мэдэж байгаа зүйл бол энэ 3 нийтлэг журмыг бид нар оруулж ирж баталж байгаа. Энэ бол 11 сарын сүүлээр батлах байх. Энэ бол хамгийн чухал зүйлийн нэг.

Мөн 96 оноос өнөөдрийг хүртэл явсан Засгийн газрын хяналтын тогтолцоог бид нар солих ажил бас үргэлжилж байна. Сая сайдын дурдсанаар энэ бол хяналт, үнэлгээ, тогтолцооны ажлыг хийхгүй бол өнөөдөр засгийн, төрийн ажил, төлөвлөлт, хяналт, үнэлгээ ерөнхийдөө гацсан маягтай байгаа. Цаасаар үйлдэгдэх системийг солих, мөн

Номинчимэг гишүүний асуултад хариулахад энэ иргэдийн сэтгэл ханамжийг 100 хувьд хүргэнэ гэдэг заалтыг бид нар яагаад тавьсан бэ гэхээ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь ингэж байгаа шүү. Номинчимэг гишүүн ээ Хяналт, үнэлгээ Үндэсний хороотой хэдүүлээ нэг, ерөөсөө Байнгын хорооныхоо хүрээнд ажлыг нь үзье, хуулийн хэрэгжилтийн талын энэ 11 сардаа багтаад хэдүүлээ энийг хэлэлцүүлээдэхье гэж байгаа шүү.

Дараа нь Зулхар гишүүн асуултаа асууна.

С.Зулхар: Байнгын хорооны дарга, гишүүд, Засгийн газрын гишүүд, төрийн байгууллагын удирдлагууд, албан хаагчдын энэ өглөөний амар амгаланг айлтган мэндчилье.

Би Эдийн засаг, хөгжлийн яамнаас маш тодорхой ганцхан л асуулт байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлаас энэ 24 оны 6 сарын 7-нд баталсан. Энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулаад бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг бас боловсруулаад явж байгаа юм байна. Төслийг нь боловсруулаад явж байгаа юм байна. Одоо энэнтэй холбоотойгоор бүсийн хөгжилтэй уялдсан саналуудыг авч байгаа. Урьд нь бас авсан байгаа юм. Баян-Өлгий аймаг 2024 оны 3 сарын 1-ний өдрийн аймгийн Засаг даргын албан тоотоор Эдийн засаг, хөгжлийн яаманд албан бичгээ хүргүүлсэн байгаа юм. Саналаа хүргүүлсэн. Тэгээд одоо энэ санал бол бүсчин хөгжлийн үзэл баримтлал дотор ер нь цох байхгүй ийм байдалтай байна.

Хоёрдугаарт бол миний авсан мэдээллээр “Бүсийн хөгжлийн энэ зорилтот хөтөлбөр” дотор бас ийм байхгүй байдалтай байна л гэж байгаа юм. Энийг яаж мэдсэн юм гэхлээр энэ хагас сайн өдөр бид нар бүсийн хөгжлийн чиглэлээр форум зохион байгуулах гэж

байгаа юм. Тэгээд тэр форумд би панелистаар оролцоно гэхлээр нь мэдээллээ хайсан чинь мэдээллээ олсонгүй. Тэгэхлээр Эдийн засаг, хөгжлийн яаман дээр энэ төлөвлөлт, хөгжлийн төлөвлөлтийг нэгтгэх ёстой, нэгдсэн удирдлагаар хангах ёстой. Энэ яагаад ороогүй юм бэ гэдэг нэг ийм асуулт гарч ирээд байна. Хэрвээ ороогүй бол энэ дагалдах баримт бичиг байгаа шүү дээ Бүсийн хөгжлийн зорилт, хөтөлбөр энд орсон уу, орох уу гэдэг нэг ийм асуулт байгаад байна. Тэгж байж нөгөө дараагийнхаа бид чинь төсөвтэй холбоотой 25 оны болон цааш цаашидаа жишээ нь, төсвийн төсөөллүүд энэнтэй уялдсан байдлаар гарна. Энэнтэй уялдсан санал гарна шүү дээ, саналууд өгнө.

Тэгэхээр энийг цаашидаа яаж зохицуулах вэ гэсэн ийм асуулт байна. Бид чинь бараг 23 жил дуншиж байж энэ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг сая баталсан шүү дээ. 23, 2001 онд баталсан тэрнээс хойш 23 жилийн дараа дахиж баталсан. Тэгсэн чинь оронд энэ дотор бүхэл бүтэн бүсийн нэг бүрэлдэхүүн хэсэг болсон нэг аймаг нь тэр чигтээ байхгүй нэг ийм байдал үүсчихсэн байна аа л гэж байгаа юм. Энийг би та бүхнээс маш тодорхой хариулт авмаар байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? 2 номерын микрофон дээр суучих. 2 номерын микрофон.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яамны газрын дарга Энх-Амгалан. Бүсчилсэн хөгжилтэй Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт ороод бүсчилсэн хөгжлийн бодлогын асуудал бүхлээрээ Шадар сайд руу шилжсэн байгаа. Амарбаясгалан Шадар сайд. Тэр Шадар сайдын харьяанд Бүсчилсэн хөгжлийн хүрээлэн байгуулагдсан. Одоо яг тэр бүсчилсэн хөгжлийн хүрээлэн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулах шатдаа явж байгаа. Тэгэхээр Шадар сайдын ажлын албанаас энд хүн байвал нэмж хариулах байх.

Ж.Бат-Эрдэнэ: Хаанаас хариулна гэнэ ээ? Шадар сайдын ажлын алба уу?

Б.Мөнх-Оргил: Уучлаарай дарга, Шадар сайдын ахлах зөвлөх Мөнх-Оргил.

Ж.Бат-Эрдэнэ: Хариул хариул.

Б.Мөнх-Оргил: Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хүрээлэн Засгийн газрын тогтоолоор Онцгой байдал.

Ж.Бат-Эрдэнэ: Битгий үймүүлээд бай Пүрэвдоржоо. Хариул. Та тэрийг нь зохион байгуулалтын ар дээр нь. Хариул хариул хариул. Пүрэвдоржоо. За хариул сонсоё.

Б.Мөнх-Оргил: За сайд аа. Бүсчилсэн хөгжлийн асуудал Онцгой байдал хариуцсан Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж ирсэн. Засгийн газрын тогтоолоор Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн байгуулагдаад үйл ажиллагаагаа хэвийн зохион байгуулаад аваад явж байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2024 оны 7 дугаар сард Засгийн газрын.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дахиад 1 минутаар сунгая, 2 дугаар микрофон.

Хөөе Пүрэвдорж дарга аа, Дэд дарга аа тэнд хүн хариулах гэж байна. Битгий үймүүлээд бай.

Б.Мөнх-Оргил: Засгийн газрын тогтоолоор Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2024 оны 7 сард Их Хурлаар баталсан байж байгаа. Энэ хүрээндээ Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Улсыг нийт 7 бүсэд хувааж, зохион байгуулалтын арга хэмжээ авч явж байгаа. Энэ сарын 26-нд Зулхар гишүүн ээ Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн маань Их Хурлын Тамгын газартайгаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартайгаа хамтран Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн яг энэ бүсчилсэн хөгжлийн чиглэлээр том

хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулна. Энэ дээр бол тодорхой бүсчлэлээс сонгогдсон, бүсээс сонгогдсон гишүүддээ илүү дэлгэрэнгүй мэдээллийг өгөхөөр манайх төлөвлөн ажиллаж байгаа.

Болсон уу Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Баярлалаа. Дарга яах вэ наадхыг чинь би араас нь яваад л асуугаад байгаа юм л даа. Тэгээд хаана ч үгүй л байгаа. Яг үнэнийг хэлье. Хаана ч үгүй байна гэдэг чинь бид бол энэ хөгжлийнхөө бодлого төлөвлөлтийг нэг газар нь бол ер нь бол бүрэн хэмжээнд бол удирдаж чадахгүй ийм байдал үүсчихлээ л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр 26-нд болох тэр хэлэлцүүлэг дээр би панелист би мэдээллээ авах гээд мэдээлэл олж чадахгүй байгаа байхгүй юу. Огт дотор нь байхгүй байгаа учраас.

Тэгэхлээр хэдүүлээ энийг би яах вэ зүгээр мэдээж ажил хэргийн шугамаар одоо та бүхэнд би нөгөө энэ Засаг даргын өгсөн бичгийг та бүхэнд албан ёсоор өгье. Энэ саналаас нь та бүхэн оруулахаа л оруулна шүү дээ. Оруулахгүйгээ оруулахгүй. Тэр чинь нөгөө тооцоо, судалгаатай. Огт тооцоо, судалгаагүй юм мэдээж оруулж болохгүй байх.

Гэхдээ ерөөсөө юу ч ороогүй байгаа байхгүй юу. Тэгээд юу ч ороогүй бол бид нар бүсчилсэн хөгжлийн тухай ярих ямар ч боломжгүй, интеграцийн тухай ярих ямар ч боломжгүй, эдийн засаг болон нийгэм жишээ нь, соёлын хөгжлийн тухай ярих ямар ч боломжгүй л болчихлоо л доо. Тэгэхлээр энийг та бүхэн анхаарч өгөөч ээ л гэж байгаа юм. Өнөөдөр би та бүхэнтэй ажилламаар байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Г.Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Бүгдээрэнд нь өглөөний мэнд хүргэе. Тэгээд 3 асуулт байна.

Нэгдүгээрт болохоор ер нь дээрээс хойш л жоохон гайхаад байсан юм Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт нийт өртөг нь 676 тэрбумаар суучихсан, 25 онд 210 тэрбумаар Засгийн газрын Нэг цэгийн үйлчилгээ Хөшигийн хөндийд гэдэг ийм төсөвт өртөгтэй барилга байгаа. Тэгэхээр энэний талаар тодруулж асуумаар байна. Өөрөөр хэлэх юм бол энэ баригдаад эхлэх гэж байна л даа. Тэгэхээр нөгөө хүн амынхаа урсгалыг яаж тооцсон юм бэ? Буцаагаад нөгөө Яармагийнх ишиг Нийслэл нь ч нүүж очдоггүй нэг байшин бариад тавьчихдаг, зөндөө хөрөнгө мөнгө зарцуулчихдаг, хэрэгцээгүй юм болчих вий гэдэг нэг асуулт байна.

Хоёр дахь нь болохоороо Эдийн засгийн яамны төсөв дээр нэг замын төсөв ороод ирсэн байна. Би тэрийг бас гайхаад яг Ки Пи Ай дээр нь болон нөгөө барих хөрөнгө оруулалтын жагсаалт дээр нь байхгүй байгаад байгаа. Энэ дээр 131 тэрбумын зам байгаад байгаа юм. Тэгэхээр нэгдүгээрт яагаад Эдийн засгийн сайдын хариуцсан ажил дотор зам явж байгаа юм бол нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ нь 25 онд төлөгдөх ёстой концесс гээд байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөө хэдэн онд хийгдсэн гэрээ юм, ажлын явц нь ямар байгаа юм гэдэг ийм асуулт байна.

Гуравдугаар асуулт болохоороо 20 минутын хот сайдын ажлын хүрээнд ТЭЗҮ 15 тэрбумаар төсөвлөгдсөн, нэвтрүүлэх, автомашины нэвтрүүлэх хурдцыг тооцоолох, төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд гэгчихсэн ийм ажил байгаад байгаа юм ТЭЗҮ-гийн ажил гээд. Тэгэхээр энэ нь өөрөө яг ямар байдлаар төсөөлж байгаа юм бол? Үр дүнг нь яаж харж байгаа юм бол? Өөрөө зураг төсөв, ТЭЗҮ гэдэг маань энэ дээр ямар нэгэн нэмэлт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийх гээд байна уу? Одоо яг ямар утгатай гэдгийг талаас нь арай жоохон нарийвчилж бас өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? 3 номер Хэрэг эрхлэх газар.

Б.Солонгоо: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Ж.Бат-Эрдэнэ: Өөрийгөө танилцуулаарай

Б.Солонгоо: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Солонгоо. Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Номтын аманд төр, захиргааны нэгдсэн байр, төрийн үйлчилгээний нэгдсэн цэг, цогцолборыг байгуулах ажил эхлээд явж байгаа. Тэгээд энэ оны төсвийн тодотголоор 100 тэрбум төгрөгийн төсөв суусан. Цаашидаа бас энэ цогцолбор маань 680 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр жил бүрийн төсөвт суухаар яваад төлөвлөж байна. 2027 онд бүрэн ашиглалтад орохоор төлөвлөж байна.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулаад, Улсын Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулаад бас Улсын Их Хурлын газраас гарсан тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд бас энэ ажил төлөвлөгдөж байгаа. Холбогдох судалгаа хийгдээд бас Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Тагнуулын ерөнхий газарт энэ төслийг бас хэрэгжүүлэхийг даалгасан бас Засгийн газрын шийдвэр гарсан. Цаашидаа Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагууд, зарим төрийн захиргааны байгууллагууд ишлэж суурьшихаар төлөвлөөд ажиллаж байна. Бүсчлэлийн хувьд Шинэ Зуунмод Нийслэл хотын дагуул хотын эдэлбэр газарт бас энэ цогцолбор байршихаар төлөвлөөд ажиллаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Хөөе тэр тагнуулын газар гээд, тагнуулын газар ямар учиртай юм? Одоо юм л бол тагнуулын газрын нэр барьдаг болчихлоо. Тендер зохион байгуулсан ч тагнуулын

газар. Тэрийг нэг тайлбарлаад өгөөч Солонгоо.

Б.Солонгоо: Бат-Эрдэнэ даргын асуултад хариулъя. Тэгээд Улсын Их Хурлаас бас Засгийн газарт үүрэг өгсөн шийдвэрт холбогдох бас энэ цогцолборыг байгуулахтай холбоотой ажлыг Тагнуулын ерөнхий газраас бас удирдан зохион байгуулахтай холбоотой бас үүрэг өгсөн. Тэгэхлээр бид нарын хувьд Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангаад ажиллаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахуушиг гишүүн.

Г.Уянгахуушиг: Энэ дээр одоо яг үйл ажил тухайн барилгын нэр нь болохоор Засгийн газрын Нэг цэгийн үйлчилгээний цогцолбор гээд байгаа шүү дээ. Тэгэхээр Засгийн газрын Нэг цэгийн үйлчилгээ чинь өөрөө яг иргэдэд зориулсан барилга байгууламж юм уу, эсвэл яг төрийн өөрсдийнх нь барилга байгууламж болох гээд байна уу? Энэ талаар саяын тайлбар дээр жоохон эргэлзээ төрчихлөө л дөө. Тэгээд дээрээс нь яг нэг цэгийн үйлчилгээ гэдэг чинь ер нь үйлчилгээг илүү амар хялбар авахад зориулагдсан байх ёстой баймаар. Тэгэхээр нөгөө төөр тэнд аваачаад байгуулчихаар чинь иргэд маань тийшээгээ урсана гэсэн үг үү? Яана гэсэн үг вэ? Энэ нь өөрөө тэр нөгөө төрийн үйлчилгээгээ хялбаршуулж байгаа бас нэг тодорхой хэмжээний ашиг тус байгаа юу, үгүй юү?

Ж.Бат-Эрдэнэ: 3 номерын микрофон, 3 номер.

Б.Солонгоо: Уянгахуушиг гишүүний асуултад хариулъя. Энэ цогцолбор маань иргэдэд үйлчлэх болон бас төрийн захиргааны төв байгууллагууд байршиж ажиллахаар бас төлөвлөж байгаа. Зураг, төсөл нь бас эцэслэгдээгүй учраас бас тодорхой мэдээлэл өгөх боломжгүй байна. Мэдээж бид нарын хувьд иргэд төрийн үйлчилгээг авахад аливаа хүндрэл, чирэгдэл үүсэхгүй

байхаар ажлыг зохион байгуулахаар төлөвлөнө. Нөгөөтээгүүр бас төвлөрлийг сааруулах хүрээнд Шинэ Зуунмод хотын төлөвлөлттэй бас уялдуулж бас энэ ажлыг бас зохион байгуулж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Өөр асуулт байгаа тээ? Тийм, Уянгахишиг гишүүн нэмэлт асуулт.

Г.Уянгахишиг: Сая энэ дээр аягүй ноцтой юм сонсогдчихлоо л доо. Юу гэхээр зураг, төсөв бүрэн хийгдээгүй байгаа гэдэг чинь юу гэсэн үг вэ? Өөрөөр хэлэх юм бол энэ 676 тэрбумын төсөвт өртөг яаж хийгдсэн байх вэ? Тэгээд зураг, төсөв нь байхгүй байхад энэ жил 210 тэрбумыг зарцуулна гэдэг маань юу гэсэн үг вэ? Ер нь энийг цааш цаашидаа ер нь нэлээн нарийн тайлбар авмаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Жавхлан сайд 5 номер.

Б.Жавхлан: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Сая ганцхан сарын өмнө 2024 онд төсвийн тодотгол Улсын Их Хурал баталсан. Тэр дотор энэ Засгийн газрын Нэг цэгийн үйлчилгээний барилгыг барилгын зураг, төсөв, мөн энэ жилдээ эхлүүлэх гэж орсон байгаа. Таны саяын ярьж байгаа дүн маань 24 оных биш, 25 оных, энэ жилийнх биш, ирэх жилийнх. Өөрөөр хэлбэл үргэлжлэх гэсэн үг байхгүй юу. Тийм. Тэгэхээр эхлүүлэх биш үргэлжлэх. Эхлүүлэх нь энэ жилийн төсвийн тодотголоор 24 онд батлагдчихсан одоо ингээд явж байгаа гэсэн үг. Тийм, тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Өөр асуулт байл уу? 2 асуулт асуусан тээ? 2 номерын микрофон Эдийн засаг, хөгжлийн яам замтай холбоотой асуудал.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Засгийн газрын тухай хуулиар төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал Эдийн засаг, хөгжлийн яаман дээр байдаг. Энэ хүрээнд концессоор хэрэгжиж байгаа

замын төсөл байгаа. Энэ нь Дархан, Сэлэнгийн авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Зэлтэрийн боомт чиглэлийн 121км авто замын төсөл концессоор санхүүжиж байгаа. Энэ нь 25 онд үргэлжлэн хэрэгжих учраас энэ дээр 131 тэрбумын төсөв тавигдсан байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбүрэн гишүүн 20 минутын хот Үндэсний хорооны дарга.

Р.Эрдэнэбүрэн: Уянгахишиг гишүүн гишүүний асуултад хариулъя. Гишүүнээ энэ Шинэ Зуунмод чинь бол 350 мянга орчим хүн амтай тийм хот болохоор төлөвлөгдөж явж байгаа. Тэгээд тийшээ гарахын тулд бол ялангуяа төрийн байгууллага түрүүлж гарч байж байж энэ 350 мянган хүнтэй хот болох ийм тооцоо хийгдэж ингээж төлөвлөгдөж явж байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Энэ авто замын нэвтрүүлэх хурдцыг сайжруулах ТЭЗҮ, зураг, төсөв гэдэг дээр яаж бодож төсөөлж байгаа юм бэ гэсэн ийм асуулт асуулаа. Ер нь яах вэ тодотголоор бол томоохон авто замыг нэвтрүүлэх хурдцыг сайжруулах томоохон төслүүд дээрх зураг, төслийн үндсэн мөнгөнүүд тавигдаад явчихсан.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Энэ Уянгахишиг гишүүний асуулт дээр бас нэг тодруулчихмаар байх юм. Тэнд энэ Нэг цэгийн үйлчилгээ баригдана тийм үү? Тэгэхээр тийшээгээ явж байгаа зам чинь тойрч явж байгаа юм уу, эсвэл нөгөө туннелээрээ явж байгаа билүү? Энэний чинь бүтээн байгуулалт яг зэрэг гарч байгаа юу? Энэ дээр нэг хариулт өгөөч. 3 номерын микрофон Солонго дарга.

Б.Солонгоо: Асуултыг тодруулж болох уу?

Ж.Бат-Эрдэнэ: Нэг цэгийн үйлчилгээ урд баригдана тийм үү? Тийшээгээ очиж байгаа урсгал чинь

туннелээр явна гээд байгаа тийм үү? Энэ туннелийн чинь бүтээн байгуулалт, Нэг цэгийн үйлчилгээ хоёр чинь яг цаг хугацаа хэр зохицож байгаа юм? Энийг л асуугаад байгаа юм.

Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм, гишүүний асуултад нэмж хариулъя. Одоо суурилагдсан байгаа дэд бүтцээр тойроод ч очиж болно. Мэдээж, хамгийн оптимальный шулуун очих нь бол туннелээрээ байж таарна. Тийм туннелийн хувьд ч тэр, энэ байгууламжийн хувьд ч тэр зураг, төсөл дээр ер нь зэрэг эхэлчихсэн явж байгаа учраас аль болох л цаг хугацааны хувьд тааруулахаар л төлөвлөж явж байгаа. Тийм.

Ж.Бат-Эрдэнэ: За за. Болормаа гишүүн асуултаа асууя. Эрдэнэбүрэн гишүүний 1 минутыг өгье.

Р.Эрдэнэбүрэн: Таны энэ асуусан энэ зураг, төсөв яаж төсөөлж байгаа юм бэ гэж. Ер нь нэг 10-12 дөрвөн замын уулзварыг 2 түвшний болгох ийм зураг, төсөл хийгдэхээр төсөөлж байгаа юм. Улаанбаатарт тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Болормаа гишүүн.

Э.Болормаа: Бүгдээрэнд нь өглөөний мэнд хүргэе. Би татвартай холбоотой хэдэн асуулт асуух гэсэн юм. Нэг тал нь Сангийн яамтай холбоотой, нэг тал нь Эдийн засаг, хөгжлийн яамтай холбоотой байгаа.

Нийгэмд нийгмийн даатгалын шимтгэл, НӨАТ-тай холбоотой нэлээн олон талаас нь хэлэлцүүлэг болж байгаа. Энэ дээр бас албан ёсоор яг Сангийн яамныхан энэ аж ахуйн нэгжүүд дээр үүсэж байгаа дарамт дээр ямар байр суурьтай байна? нийгмийн даатгалын шимтгэлийг болон НӨАТ-ыг энэ жил, ирэх жил 25 оны төсөв дээр хөндөөгүй учир шалтгаан, цаашидын бодлого баримталж байгаа бодлого юу юм бэ

гэдэг дээр бас дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч гэж байгаа юм. Манай эдийн засаг нийтдээ уурхай дээр давамгайлан тогтдог гэдэг. Гэтэл өнөөдөр манай төсвийн орлогын яг 31 хувийг уул уурхайн салбараас бид бүрдүүлж байна. Дан ганц НӨАТ-аас гэхэд бараг үүнтэй дүйцэхүйц хэмжээгээс бид бүрдүүлж байна. Өнгөрсөн жил гэхэд л 6 их наяд, нийт 28 их наядын төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 6 их наяд нь НӨАТ-ын орлогоос бүрдсэн байна.

Тэгэхээр бараг уул уурхайн салбартайгаа дүйцэхүйц орлогыг НӨАТ-оос олно гэдэг Эдийн засгийн, хөгжлийн яамны зүгээс би бас цаашидаа бид дундаж давхаргаа тэлэх энэ бодлого дээр аж ахуйн нэгжүүд, иргэдийн амьдралын чанар эдгээр зорилтуудтайгаа энэ хэрхэн бодлогоор уялдаж байгаа вэ гэдэг талаар бас асуулт асуумаар байна. Үүнээс гадна энэ удаагийн төсөв дээр татвар нэмэхгүй гэдэг ийм нэгдсэн зарчимтай орж ирсэн.

Харин миний хувьд өмнө нь бид бас хэрвээ би буруу санаагүй бол Сангийн яаман дээр хэлэлцэж байсан жишээлбэл, өндөр үнэтэй машины татвар гэх мэтчилэн зүйлсийг яагаад оруулж ирээгүй юм бэ? Манай Монгол Улс бараг л 1 хүнд ноогдох Ланд 300-гийнхаа хэмжээгээр дэлхийд нэгд жагсааж байгаа байх. Зөвхөн 24 оны хүртэлх борлуулалтыг харахад 3000 гарчихсан л явж байх шиг байна.

Тэгэхээр эдгээр өндөр үнэтэй ч юм уу, магадгүй үүнээс гадна Синтакс гэж ярьдаг импортын архи дээр ч юм уу, тамхи дээр ч юм уу татвар нэмэх асуудлуудыг бодсон уу? Би энийг яагаад ярьж байна вэ гэхээр сая Эрүүл мэндийн даатгалын сан энэ төсөв дээр ч гэсэн харагдаж байна л даа. Бид нар цаашидаа хэрхэн тогтвортой байлгах вэ гэдэг. Тэгвэл бид төсвийн орлогыг яг тэр салбар салбартай нь уялдуулж нэгдсэн нэг төсөв рүү л мөнгө ороод л тэндээс бүх тал руу тараах биш салбар

салбартаа илүү ухаалаг байх боломж байна уу?

Жишээлбэл, замын засварын мөнгийг яг бензин дээр нь татвар аваад тэр нь замын засвар руу ордог, Эрүүл мэндийн даатгалын сан руу, магадгүй импортын архи, тамхи дээр татвар тавиад тэр нь шууд Эрүүл мэндийн даатгалын сан руу ордог гэх мэтчилэн татварыг арай тийм ухаалгаар, зориулалтын байдлаар нь хийх боломж байна уу гэсэн ийм асуулт байна.

Тэгэхээр энэ татвартай холбоотой нөгөө талаар би Эдийн засаг, хөгжлийн яамнаас яг онцгойлон бүр хэрхэн энэ дунд, ЖДҮ-лэлийг дэмжихээр цаашидаа дундаж давхаргыг тэлэх аж ахуйн нэгжийн бодлогыг юу гэж харж байна? Зөвхөн татвар гэлтгүйгээр тэрэн дээр хариулт авъя.

3 дахь нь маш товчхон асуу.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Болормаа гишүүн ээ энэ нөгөө бид нар чинь эрхлэх асуудлынхаа хүрээнд асуултуудаа асуух ёстой. Саяын татвартай холбоотой асуудал чинь Төсвийн байгууллагын, Төсвийн байнгын хорооны хүрээнд л хариулах л асуулт болж байна. Тэгэхдээ Жавхлан сайд хариулах уу? Саяын асуултад хариулчих.

Б.Жавхлан: Татвар уу? Болормаа гишүүний асуултад хариулъя. Аж ахуйн нэгжийн албан татварын хувьд бид 2019 онд буюу 5-хан жилийн өмнө багц реформ хийсэн. Тийм, тэгэхээр одоо бид тэр хийгдсэн үеэс хойш энэ реформынхоо юу гэдэг юм, үр дүнг харах, эргээд реформ гэж яриад дахиад багцаар нь өөрчлөх энэ цаг хугацааны хувьд хэтэрхий ойрхон байхгүй юу. Дүн шинжилгээ хийх ч тийм боломжтой хугацаа энэ бол биш. Мэдээж засаж, янзлах ийм зүйлүүд байлгүй яах вэ.

Тэгэхээр энэ 4 жил бид нар яаж явж ирсэн бэ гэхээр ер нь татварын

хувь, хэмжээ дээр бид нар огт оролдоогүй. Процессын хувьд реформыг шинэчлэх, ил тод болгох, цахимжуулах, тайлагнах, татвар авах энэ процессуудыг маш их хөнгөвчилсөн байгаа. Тэгсний үр дүнд ч сүүлийн жилүүдэд энэ татварын орлого маань тогтвортой нэмэгдэж байгаа. Ийм үр дүн гарч ирж байгаа.

Тэгэхээр татварын дарамт гэдэг өөрөө тийм харьцангуй ойлголт. Ямар ч дарамтгүй татвар гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр татварын дарамт гэж байгаа ойлголтыг яг ямар өнцгөөс яаж харж байна? Хяналт, шалгалт дээрээ дарамттай байна уу, тайлагнах дээрээ хэцүү, ойлгомжгүй байна уу? Одоо энэ цахимжаад байгаа нийгэмд тэр нь хоцроод байна уу? Энэ бүгдийг их олон талаас нь харж ингэж энийг бид нар цаашид сайжруулах хэрэгтэй.

Сүүлийн 4-5 жилийн хугацаанд татварын салбарт энэ цахимжуулах, тайлагналыг ил тод хялбаршуулах, ялангуяа ЖДҮ-лэгч, малчид, иргэдийн бас энэ санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, татварын орчинд тайлагнах, татварын аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ард иргэдийг, жижиг бизнес эрхлэгчдийг ийм процессууд их сайн үр дүнгээ өгч ингэж явж байгаа.

Гэсэн хэдий ч та бүхэн мэдэж байгаа Засгийн газрын 100 хоногийн эхний ажлын төлөвлөгөөнд бид энэ татварын орчныг илүү сайжруулах, ойлгомжтой болох реформыг үргэлжлүүлэх ийм үүргийг авсан байгаа. Ингээд Сангийн яам энэ дээрээ ажиллаж байгаад 100 хоногийн дараа бид хэрхэн, ямар өнцгөөс, ямар хэмжээнд, яаж хэрэгжиж цаашаа явах вэ гэдгийг илүү бодитойгоор тайлагнаад явна.

Нийгмийн даатгалын шимтгэлийг ярьдаг. Энийг ч гэсэн дээ мөн ер нь нэг олон талаас нь харах хэрэгтэй. Энэ нийгмийн даатгалын шимтгэл бол татвар биш, төсвийн орлогод ороод, зарлага шингээд явдаг ийм зүйл биш. Энэ

ажил олгогч талаасаа ч тэр, ажилтан талаасаа ч тэр ирээдүйдээ тэтгэвэрт гарах үедээ энийг хэрэглэх зорилготойгоор нэг ёсоор хадгалуулж байгаа ийм хуримтлал шүү дээ. Ажил олгогч гэрээ, хөдөлмөрийн гэрээгээр ажилтан аваад ажиллуулж байгаа бол тэр хүний өмнө ч хүлээж байгаа хариуцлага, нийгмийн өмнө ч хүлээж байгаа ч хариуцлага. Тэр хүний ирээдүйн нийгмийн даатгалыг нь төлж байгаа ийм хариуцлага байгаа байхгүй юу. Энэ тогтолцоо маань ч өөрөө хуримтлал руу шилжиж аажмаар явж байгаа ийм зүйл байгаа. Яг тогтолцооны асуудал ярих юм бол хэдэн цаг ярих асуудал гарах байх.

Тийм учраас ер нь иргэн хүн ажил, ажилтан, ажил олгогч талаас аль аль талаасаа л бас энийг ийм өнцгөөр нь харж энэ дээр явах хэрэг хэрэгтэй. Тэрнээс биш энийг татвар гэж, татварын дарамт гэж ойлгож энийг болохгүй.

Тэр тансаг хэрэглээний татварыг бол бид ярьдаг. Ялангуяа бид Сангийн яам талаасаа бол яг Засгийн газраас заавал Улсын Их Хуралд гэлтгүй өөрсдөө зохицуулалт хийгээд явах ийм хэд хэдэн татварын төрлүүд байдаг.

Тийм учраас энэ бол өөрөөр хэлбэл, татварын орлого бүрдүүлдэг татварын төрөл гэхээсээ илүү энэ салбар дундын зохицуулалтын татварын төрөл юм байгаа юм. Одоо энэ жишээ нь, таны яг онцолж хэлж байгаа тэр өндөр моторын хэмжээтэй ийм машинуудын хувьд Улаанбаатар хотын түгжрэл ч байдаг юм уу, хүн амын түгжрэл, нягтрал энэтэй холбоотой ийм хариу арга хэмжээ авъя гэдэг ийм санал, судалгаатай ирвэл бид энэ саналыг бас оруулаад явахад.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Наадах чинь тэр Төсвийн байнгын хороон дээрээ ярилцсан нь дээр байх аа. Тийм. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ төсвийн хууль орж ирж байна. Тэгээд ерөөсөө энэ зардлуудаа ерөөсөө багасгаагүй байна. Би энэ оны эхнээс эхлүүлээд тоолоод 128 хүргээд энэ хажуу талд байгаа Их танхимд болсон хурал, цуглаан, семинарыг 128 хүргээд 5 сарын сүүлээр алдаж байсан байхгүй юу. Тэгээд л одоо л жишээ нь, “Юү Жи Арена”-д 3-хан арга хэмжээ зохион байгуулахад л тэрбум орчим төгрөг шилжүүлж байсан. Тэр багш нарын, малчдын гээд л. Манай Ховд аймгаас нэг мэргэжилтэн үгүй ээ би гишүүн ээ 4 дэх удаагаа ирж байна гээд л нэг юм 4 удаа наашаа ирээд энд семинарт оролцоод, тэгээд зардлаа даалгаад, энд үнэтэй буудалд ороод хоол унд идээд л, тэгээд л баахан тор дүүрэн юм аваад л. Тэгээд энэ жилжингээ сургалт, семинар болсон байхгүй юу. Хэдэн тэрбум, их наядаар нь зарцуулсан. Тэр болгон юунд зарцуулагдсан бэ гэх дээр ерөөсөө энэ төрийн албан хаагчдыг бүгдийг нь Ардын намд санал өгүүлэх тэр бүх арга хэмжээг бүгдийг нь зохион байгуулсан байхгүй юу. Тэгээд энэ зардал чинь ерөөсөө бууж орж ирээгүй байна шүү дээ.

Энэ хэрээс хэтэрсэн зардлууд чинь юу, энэ урсгал зардлууд байгаа янз янзын тэр байр, ашиглалтын зардалтай холбоотой, тэгээд л хангамж материалтай холбоотой, томилолт, зочны зардалтай, бусдаар гүйцэтгэх ажлууд нь ерөөсөө урд талын жилээсээ ерөөсөө буугаагүй бүр өсөөд ороод ирчихсэн. Тэгэхээр улам их семинар хийнэ гэсэн үг шүү дээ. Семинар хийгээд Монгол Ардын нам хөгжүүлчихсэн хаана байгаа юм? Тэр нь доошоо тэгээд л ерөөсөө яамнуудаасаа доошоо явна, тэр аймаг дээр очно, аймгаасаа бүх төрийн албан хаагчид, янз янзын малчин эмэгтэй, бүх хүмүүсийг тэр, Монголын бүх хүмүүсийг аймаг дээр дуудаж авчирч семинар, найр хийсэн.

Тэгээд төсвийн мөнгийг зарцуулсаар байгаад гишүүн болчихсон нөхдүүд энэ тоо томгүй их. Ийм замбараагүй зардлаа тэгээд энэ жил

ерөөсөө засахгүй орж ирсэн байна шүү дээ. Тэгээд хэдэн 10-н, бараг арваад их найдаар нэмэгдүүлчихсэн өнгөрсөн оны төсөв батлуулснаас хойш. Тэгээд энэ татвар төлөгч нар руугаа хандсан ерөөсөө ямар ч арга хэмжээ байхгүй. Ер нь дэлхий даяар ганцхан л юм байгаа шүү дээ. Төсвөөрөө дамжуулан хувийн хэвшилээ хамгийн сайн дэмжсэн тэр улс орнууд л хамгийн сайн хөгжилтэй байж байгаа.

Гэтэл ерөөсөө юу руугаа хандсан, тэр татвар төлөгчдөө тэр нэг ажил олгож байгаа хүмүүсээ илүү сайжруулсан зүйл байхгүй байх. Байдгаараа л өөрсдийнхөө зардлыг нэмэгдүүлсэн ийм төсөв орж ирсэн байна.

Тийм учраас энэ дээр бүлэг бас тодорхой шийдвэр гаргах ёстой. Завсарлага авах байх.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Би энэ Улсын Их Хурлын Тамгын газраас асууя. Их Хурлын дарга маань энэ хэм хэмжээний актуудыг цэгцэлье, журмаар нийгмийн харилцааг зохицуулдаг больё гээд бас нэлээн ярьж байгаа. Хууль зүй, дотоод хэргийн яам ч гэсэн энэ чиглэл рүү анхаарч нэлээн ажиллаж байна. Тэгэхдээ яг үнэндээ манай улсад энэ хэм хэмжээнийхээ журмыг байхгүй болгоно гэдэг чинь зүгээр текстийг нь копидож байгаад хууль дотор ороод тавьчихдаггүй юм аа. Энэ өөрөө хууль зүйн маш нарийн техник, мэргэшил, боловсрол шаарддаг ийм ажил. Улсад маань энэ чиглэлийн боловсон хүчин, хүний нөөц багавтар байна.

Тэгээд ажиллуулаад, ажил зохион байгуулахаар бас нэлээн төсөв, хөрөнгө ярьдаг. Тэгээд энэ Их Хурлын Тамгын газраас орж ирж байгаа төсөв, төлөвлөгөө дотор энэ Их Хурлын гишүүд баахан Их Хурлын гишүүдийг оролцуулаад ажлын хэсгүүд

байгуулчихсан, 50 гаруй ажлын хэсэг юм шиг байгаа юм. Тэгээд Их Хурлын гишүүд маань өөрсдийнхөө хуулиар хүлээсэн чиг үүрэг, хууль санаачлах эрхээ эдэлнэ, ажил хийнэ гээд байдаг. Тэгэхээр энэ хуулийн төсөл боловсруулах үйл явцад нь мэргэжилтнүүдээс туслалцаа авахаас аргагүй, гэрээ байгуулахаас аргагүй болно. Энийг ойлгож байгаа.

Тэгэхээр энэ хэм хэмжээний актаа цэгцлэх, энэ хуулийн төсөл боловсруулахад тодорхой хэмжээний зардал тавьсан гэж ойлгож байгаа. Тэгэхээр яг энэ хэм хэмжээний аль алиныг нь тусад нь, гишүүдийн хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хэчнээн төгрөг, 1 гишүүнд ер нь ямар хэмжээний зардал тооцчихсон байгаа юм? Дараа нь яг энэ хэм хэмжээний актыг цэгцэлнэ гэж байгаа. Энэ ажлыг ямар далайцтайгаар, ямар хүн хүчээр зохион байгуулна гэж тооцож тусгасан юм бэ гэдэг ийм тодорхой асуулт байна.

Ж.Бат-Эрдэнэ: Тамгын газар уу? Улсын Их Хурлын Тамгын газраас хэн хааччихав? Байхгүй байна уу? Хэн ороод ирэг, Баасандорж ороод ирээ. Алтангэрэлээ Баасандоржоос асуусан уу? Баасандорж дарга ороод ир. Жавхлан сайд хариулах уу? Баасандорж дарга ороод ирэг тэгээд хариулья.

Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Энэ Төрийн байгуулалтын байнгын хороонд хамаарах байгууллагуудын төсөв байна л даа. Эргүүлээд харахлаар би та нарт уншъя. Ерөнхий сайдын төсөв 50 тэрбумаар, Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргынх 10 тэрбумаар, Улсын Их Хурлын даргынх багцаа ойролцоо хэлж байна шүү, 50 тэрбумаар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргынх 120 тэрбумаар, Шадар сайдынх 50 тэрбумаар, Төрийн албаны зөвлөлийнх 14 гээд. Хамгийн багадаа 20-30 хувь нь. Тэгэхдээ энэ чинь 24 биш сая 8 сарын тодотголоос хойш хамгийн

багадаа 20-30 хувь бүгдээрээ тус бүр өсчихсөн.

Тэгээд энэ эдийн засаг нь үнэхээр ийм сайн сайхан байгаа юм уу? Мөнгө нь багтаж шингэхээ больчихоод төсөвт төлөвлөгөө ингээж нэмээд байгаа юм уу гэхээр нөхцөл байдал яг ямар байна вэ? Сая 24 оны гүйцэтгэлээр Монгол Улс төлбөрийн тэнцэл 600-гаад сая долларын ашигтай гарч байсан байх. Энийг дагаад тодорхой хэмжээний валютын нөөц нэмэгдээд, энийг дагаад валютын хани, төгрөгийн хани тогтворжиж байсан.

Гэтэл сая 9 сарын гүйцэтгэлээр чинь төлбөрийн тэнцэл чинь хасах болчихлоо. 260-аад тэрбум, 60-аад сая долларын хасах гарч байна. Энэ хасах чинь яг одоо та бид нар хэвлэл мэдээллээс, юунаас харж л байна. Наад валютын нөөц чинь нэлээн хэмжээгээр буурчихлаа. Дахиад хани, төгрөгийн хани чинь дээшээ явж эхэлж байна. Бодит байдал дээр наад эдийн засаг чинь тийм сайн байхгүй байна шүү дээ. Нүүрсний үнэ чинь 1 жилийн дотор 30 хувь уначихсан, валютын хани чинь эргээд хүндрэлтэй болчихсон, төлбөрийн тэнцэл чинь алдагдалтай болчихсон. Ноднин жил ашигтай байсан бол энэ жил алдагдалтай болчихсон.

Тэгж байхад ширхэгчлэн энэ бүх байгууллагуудын төсөв чинь, дарга нарын төсөв, төрийн төсөв 20-30 хувь. Тэгэхээр энэний цаана чинь ийм яг ямар нөөц бололцоо байна гэж та нар энэ төсвөө ингээж таамаглаад? Яг нөхцөл байдал чинь өөрөө алдагдалтай, наад нүүрсний чинь үнэ уначихсан, төмрийн хүдрийн чинь үнэ уначихсан, нөхцөл байдал тийм гол худалдан авагч чинь таатай биш, гол хэрэглээ тэр металлургтай холбоотой түүхий эдүүдийн чинь үнэ таатай биш байхад яг юунд үндэслэж ийм их өндөр, нэг байгууллага энэ зөвхөн энэ Төрийн байгуулалтын байнгын хороонд хамаарах 11 байгууллагын төсөв чинь хамгийн бага нь 20 хувь өсчихсөн ийм л байдалд байна шүү дээ. Тэгэхээр энэ ер нь хэр үндэслэлтэй юм бэ гэдэг чинь яах

асуухаар та нар тэгээд л үндэслэлтэй гээд л гоё гоё юм л ярьчихна л даа. Зүгээр нөхцөл байдал чинь өөрөө ийм таагүй байна шүү. Наад валютын хани чинь өөрөө дарамт ханинд, наад гадаад худалдаа чинь, төлбөрийн тэнцэл чинь таагүй болоод эхэлчихсэн, гадаад зах зээлийн эрэлт чинь таагүй болоод эхэлчихсэн ийм байхад энэ наад төсөв энэ хэт өөдрөг гэдэг юм уу, хэт улс төрийн зорилготой гэдэг юм уу энэ төсвөө бас нэг эргэн харах шаардлагатай юм биш үү л гэдэг саналыг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Энэ ерөнхий юм яриад яах вэ энэ өнөөдрийн энэ юутай холбоотой л юм л хэлье гэж бодож байна. Би нэг иргэдийн мэдээллийн төв гээд л нэг юмтай ноцолдоод байгаа юм л даа. Тэгээд Жавхлан сайд намайг хөдөө явж үз гэсэн, хэрэгтэй эсэхийг нь шалгаад ир гэсэн. Би тэгээд сая хөдөө явсан, Завхан аймаг явсан, Өмнөговь явсан. Тэгээд энэ иргэдийн мэдээллийн төв хэрэгтэй эсэхийг тухайн иргэдээс асуухад огт хэрэггүй гэж хэлсэн. Энэ нэг хэрэг.

Тэгээд би бас Ерөнхий сайдад асуулт тавьсан байсан. Энэ 10, 14 ширхэг сум байгаа юм л даа. Тэгээд энэ 14 сумд мэдээллийн төв барих гэж байгаа сумд эрүүл, стандарт хангасан эмнэлэг байна уу? Стандарт хангасан цэцэрлэг байна уу? Хэдэн соёлын төв байна вэ? Халуун усны газар байна уу? Дотуур байр болон сургууль нь боловсон нойлтой юу гээд асуулт тавьсан. Хариулт нь ирсэн. Тэгээд энэ хариултауд дээр нь дүгнэлт хийгээд үзэхэд энэ 14 сумын 6-д нь эмнэлэг нь шаардлага хангаагүй ээ гэж Эрүүл мэндийн сайд ирүүлсэн. Нэг нь бүүр 82 оны барилга гэж байгаа юм. Тэгээд 14.6 нь ерөөсөө шаардлага хангаагүй гэдэг. бүүр ийм өгүүлбэр, шаардлага хангасан эсэх талаар асуухад шаардлага хангаагүй

барилга нь хуучирсан гэж байгаа юм. Энэ чинь эмнэлэг шүү дээ. Нэг.

4 газар нь, 5 сумд нь шинээр соёлын төв баригдчихсан байна. Өөрөөр хэлбэл, тухайн сумд 2 ширхэг соёлын төв байна. Тэгээд эмнэлэг нь эрүүл мэндийн шаардлага хангахгүй байна, боловсон нойл бол байхгүй шинэчлэгдэж байгаа гэж байгаа. Тэгээд ийм нөхцөл байдалтай байхад яагаад энэ эрүүл, юуны мэдээлэл өгөх төв гэж оруулж ирсэн юм бол? Энэ чинь сая тодотголоор орж ирсэн шүү дээ. Тэгээд барилгын явц, санхүүжилтийн дүнг бас би асуусан. Энэ чинь ердөө аргагүй шүү дээ 9 сарын 1-нд шахам батлагдсан юман дотор чинь би асуулга асуухад сая 10 сарын дундуур хариулт нь ирэхэд бол 5 хувьтай, 10 хувьтай, тендер зарласан гээд бүүр нэг яаж нэг яах вэ гэсэн байрын, нэг юм хийсэн дүр эсгэх вэ гэсэн байрын. Ихэнх нь гүйцэтгэл 5, гүйцэтгэл 5, гүйцэтгэл 10, гүйцэтгэл 5 гээд. Одоо энэ асуулгад зориулсан, зориулж юм хийгээгүй л байлтай билээ.

Тэгэхээр энэ эмнэлэг нь стандартын шаардлага хангахгүй байгаа энэ сумууд дахь энэ иргэдэд мэдээлэл өгөх төвөө больж болохгүй юм болов уу? Иргэд нь өөрснөө хэлээд байгаа шүү дээ. Өө ердөө хэрэг байхгүй гээд. Би нэг хүний ярилцлагыг тавьсан. Анзаарсан хүн байна уу, үгүй юу? Одоо сумын ажилчид нөгөө хөдөө малчдад очоод мэдээлэл хийлгэхээр өөдөөс хэлээд байдаг гэж байгаа шүү дээ. Өө лайваар үзсэн, өө үзсэн гээд л ерөөсөө өөдөөс нь.

Тэгэхээр яг ямар мэдээлэл өгөх гээд байгаа юм бэ? Дээрээс нь тэр хүн хэлж байсан шүү дээ. Иргэний танхим гээд бас байж байгаа манай юун дээр, Тамгын газарт. Үгүй ээ тэгэхээр мэдэхгүй хэн ч тийшээ очиж мэд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Эрхлэх асуудлын хүрээний биш ч гэсэн Жавхлан сайд хариулах уу? Эмнэлэг, сургууль асуусан уу сая?

Б.Жавхлан: Тийм, гишүүний асуултад хариулъя. Асуултыг нь би сайн ойлгосонгүй. Ямар ч байсан би бидэнд байгаа статистик тоог хэлье. Ирэх жил 90 сургууль үргэлжилнэ, эндээс ашиглалтад оруулах нь бол 60, 70 хувь нь байгаа. 61 цэцэрлэг байгаа, 31 эмнэлэг байгаа. 13 сумын энэ төрийн албаны, төрийн захиргааны гол үйлчилгээ үзүүлдэг энэ мэдээллийн төв ийм барилгууд үргэлжилж байгаа. Та хаанаас ингээд тоо хараад, зөрөөд давхиад байдаг юм? Би сайн хэлж мэдэхгүй юм. Тодотгол дээр ийм төрлийн шинээр эхлүүлэх барилга, байгууламж 1 төгрөгийн ч төсөл орж ирээгүй. Тэгэхээр эдгээр төслүүд төсвөөр санхүүжигдэхдээ энэ хэд хэдэн шалгуур, хэд хэдэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын хүсэлт, мөн цаанаа хийгдсэн судалгаа, шаардлага эрэмбийн дагуу орж ирдэг. Ингээд багтаад явдаг. Тэр дотор ард, иргэдээс санал авч орж ирдэг ийм зарчим сүүлийн жилүүдэд нэлээн сайн практик болж ирж байгаа.

Тийм учраас одоо тэр ард, иргэдээс санал асуулга аваад, бүүр нийтээр нь санал асуулга аваад тэд нар нь дургүйцээд ерөөсөө ингэсэн зүйл хаана байгаа юм бол? Та тийм судалгаанууд байвал үзүүлээрэй. Тэр нь зөрөөд давхиад байвал.

Ер нь яах вэ сум, багийн түвшинд төрийн үйлчилгээ үзүүлдэг нэг хэдхэн ийм төвлөрсөн цэг, байгууламжууд байдаг, Тэр нь Тамгын газрын барилга, соёлын төв, спорт цогцолбор гээд хэдхэн барилгууд байдаг. Энийг дагаад энэ чинь төрийн үйлчилгээ тэнд явж байгаа юм. Ард иргэд маань ёстой алслагдсан гээд энэ төрийн үйлчилгээнээс хоцорч болохгүй. Энэ төрийн үйлчилгээг төрийн захиргааны энэ байгууламжууд бол бас 1 иргэнийг ч гээхгүйгээр иргэнийхээ ардаас иргэнийхээ төлөө явсан ийм л үйлчилгээ. Тэрийг нь Засгийн газар төсөв өөрөө санхүүжүүлж байх үүрэгтэй юм байгаа юм. Тухайн яг тухайлсан яг сум дээр аль нь хоцорсон байна, аль нь хуучин байна,

алийг нь түрүүлж барих шаардлагатай байна? Энэ бүх зүйлүүд бол нэлээн судалгаатай, ялангуяа манай Боловсролын яам, Эрүүл мэндийн яамны хувьд энэ судалгаанууд яг тийм газар зүйн байрлалыг майтин-гийн судалгаа бол маш сайн хийгдэж ирж байгаа сүүлийн жилүүдэд. Энэ шаардлага эрэмбээрээ санхүүжигдээд хийгдээд явж байгаа.

Ер нь ер нь энэ 3-4 төрлийн сум дээр байдаг энэ төрийн захиргааны үйлчилгээний барилгуудыг бол сүүлийн жилүүдэд нэлээн шинэчилсэн, бүүр хоцорсон байхгүй байгаа ийм сумдуудыг ч гэсэн аль болох түлхүү оруулаад явж байгаа. Цаашидаа ч энийгээ бид үргэлжлүүлнэ.

Энэ төрийн Монгол Улсын өөрөө энэ төр захиргааны байгууллага энэ нэгжийн зохион байгуулалтын хувьд энэ 365 сумынхаа бүтэцтэй байгаа үед бид энийг цаашаа үргэлжлүүлэх л болно. Энэ сумдуудаа татан буулгаад, аймаг аймгийн зохион байгуулалтад оруулдаг ч юм уу, энэ 100 жил явж ирсэн бүтцэд хэрвээ цаашидаа өөрчлөлт орж ирнэ гэвэл тэрийг дагаад харин магадгүй энэ төрийн үйлчилгээний бүтэц, энэ барилга байгууламжийн асуудлууд газар зүйн байрлалын хувьд, бас дараагийн өөр шилжилт бодлогын хувьд хийгдэхийг үгүйсгэхгүй.

Одоо байгаа 365 сумдаа ард иргэдээ ингэж хувааж, ингэж байршуулж, ингэж 100 жил явж ирчхээд одоо гэнэт эргээд тэнд нь төрийн захиргааны барилга байж болохгүй, энд нь соёлын төв байж болохгүй гэж болохгүй. Энд чинь төрийн үйлчилгээ явж байгаа гол ийм цэгүүд нь байж байдаг.

Харин хаана шаардлагатай вэ, хаана шинэчлэх шаардлагатай вэ, хаана урсгал засварыг нь хийх вэ, хаана нь их засварыг нь хийх вэ гэдэг тухайн яг төсвийн ерөнхийлөн захирагчийн бодлого, судалгаан дээр үндэслэгдэж ингэж явна.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн тодруулъя.

Ж.Баярмаа: Жавхлан сайд шинээр ороогүй гээд байх юм. Энэ чинь, та арай ч дээ тэгж хэлж болохгүй шүү дээ. 2024 оны тодотголоор орж ирсэн шүү дээ. Тодотгол. 24 оны төсөвт ч байгаагүй. Би тэр төсөв батлахад байгаагүй учраас мэдэхгүй биш байхгүй юу. Энэ чинь хараад, харж байна шүү дээ тодотголоор. Тэгээд тийм юм орж ирээгүй гээд байх юм. Улаан цагаан орж ирсэн шүү дээ. Энэ байна шүү дээ энэ жагсаалт нь. Үгүй, батлагдсан биш тодотголоор. Би энийг чинь маш нарийн харсан. Тэгээд энэ чинь эрэмбэ дараалал гэж байх ёстой биш юм уу энэ төсөвт чинь? Үгүй ээ тэгээд энэ эмнэлэг байхгүй байна аа шаардлага хангасан, 82 оны эмнэлгийн барилгатай байна гээд сум нь хэлээд. Би судалгаа авсан байхгүй юу. Ерөнхий сайдаас асуулга тавьж байгаад. Би зохиож ярихгүй шүү дээ. Тэгээд үр ашигтай байдал гэж зарчим байдаггүй юм уу? Нөгөө 4, 5 зарчмын чинь нэг нь энэ улсын төсөв, төсөв, төсвөөс санхүүжиж байгаа энэ бүх хөрөнгө оруулалт чинь үр ашигтай байх ёстой гэдэггүй юм уу? Тэгэхээр энэ яг ямар үйлчилгээ үзүүлэх гээд байгаа юм? Та тэгвэл тэрийг нь яг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн наа чинь Эдийн засгийн байнгын хороон дээр л ярих асуудал уу? Эсвэл Төсвийн байнгын хороон дээр ярих асуудал байх шиг байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.3-д зааснаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал гаргасан гишүүн саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно, санал гаргаж болно гэж байгаа. 3 санал ирсэн байгаа.

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Ирүүлчихсэн байгаа билүү? 3 гишүүн санал ирүүлсэн байгаа. Эндээс Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан гишүүн санал ирүүлсэн, Лувсанжамц гишүүн санал ирүүлсэн, Баярмаа гишүүн санал ирүүлсэн тийм үү? Ингээд Баярмаа гишүүний санал болохоор Төсвийн байнгын хороон дээр санал хураагдах, юу гарах санал байна. Тийм тийм байна. Амарсайхан гишүүнийх болохоор Эдийн засгийн байнгын хороо руу очих санал байна. Энд нэг л санал орж ирж байна тийм үү? Уншаадахъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 25 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн нэр өөрчлөх санал.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 17.3.5.1-д тусгагдсан “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох” гэсэн хөтөлбөрийн нэрийг “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц гэж байна.

Лувсанжамц байхгүй байгаа тээ? Санал хураалт.

15 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Одоо энэ. Явчихлаа тээ? Болж байна.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, хэн танилцуулах вэ? Зулхар гишүүн танилцуулах уу? Зулхар гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа.

10.53 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР